



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 9/2014

Улаанбаатар хот

Төслийн менежер болон хяналтын инженер  
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Олон улсын шинэ нисэх буудлаас дулааны станц хүртэлх 2.9 км хатуу хучилттай авто зам барих ИНЕГ/УТ/ТББ/А-01/17 дугаар гэрээт ажилд хяналт тавих Төслийн менежер, Хяналтын инженерийг 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус томилсугай.

Төслийн менежер: Н.Мягмарсүрэн Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Дэд бүтэц, техник ашиглалт хариуцсан дэд дарга

Хяналтын инженер: Э.Мөнх-Эрдэнэ Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Барилга байгууламж, засвар арчлалтын хэсгийн аэродромын ашиглалтын инженер

2. Гэрээт ажилд хяналт тавихад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, гэрээт ажлыг ашиглалтад авахтай холбогдон гарах бусад зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гарган зарцуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН